

## ХУРААНГУЙ

2009 онд батлагдсан Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн Үндэсний стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой хууль тогтоомжид, бодлогын судалгаа” хийхээр төлөвлөсөн байна.

Иймд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн судалгаа хийж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангахад энэхүү судалгааны зорилго оршиж байна.

Судалгаанд контент анализийн аргыг ашиглан, нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой эрүүл мэндийн бодлого, хууль эрх зүйн орчны болон бусад холбогдох баримт бичгийг авч үзэн, эх баримт бичгээс нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой тусгагдсан заалтуудыг түүвэрлэн, дүгнэлт хийлээ.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилтийн бодлого, эрх зүйн орчны судалгаанд 5 бодлого, 5 хууль, 7 стратеги, 2 үндэсний хөтөлбөр, 13 журам, шийдвэр, 4 тусламж, үйлчилгээний технологи, нийт 37 эрх зүйн баримтыг судалсан.

Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн тогтвортой байдлыг хангах, эм, хэрэгслийг хадгалах, түгээх, орон нутагт тээвэрлэн хүргэх, төлбөрийг төр хариуцах эмийг олгох, импортлох, хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах, амин чухал, эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт нь ЭМЯ-тай гэрээ байгуулсан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд буюу эм хангамжийн байгууллагаар дамжин хэрэгжиж, эмийн сангаар түгээгдэж байна.

Нөхөн үржихүйн эм, хэрэгслийг хуваарилах, түгээх нэгдсэн зохицуулалтыг ЭМЯ, орон нутагт Эрүүл мэндийн газар зохицуулж байна. Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн цөөнгүй хувийг олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрөөс хангах эрх зүйн орчин бүрдсэн ба 2016 оноос улсын төсвөөр бүрэн санхүүжүүлэхээр бодлого, стратегид тусгасан байна.

Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон 7 нэр төрлийн нөхөн үржихүйн эм, бэлдмэлд үнийн хөнгөлөлт үзүүлэх, эмзэг давхаргын иргэдэд нөхөн үржихүйн эм, хэрэгслийг үнэ төлбөргүй олгох, эх нярайн тусламж, үйлчилгээ, хүний дархлал, хомсдолын болон дархлалын олдмол хомсдол өвчний эмчилгээг төрөөс санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Монгол улсын эмийн талаар төрөөс баримтлах бодлогын хөгжлийн хэтийн төлөвийн хугацаа 2012 онд дууссан, дараагийн шинэчлэлийн үе шатанд ирсэн байна.

## НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, АРГАЧЛАЛ

### 1.1. ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын 2 сая 930.3 мянган хүн амын 68.1% нь хот суурин газарт, 31.9% нь хөдөө амьдарч байгаа ба нийт хүн амын 48.7% нь эрэгтэйчүүд, 51.3% нь эмэгтэйчүүд байна.

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд дөрөв дахин бууруулах”-аар тусгасан.

Энэхүү зорилтыг ханган “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн дөрвөн удаагийн Үндэсний хөтөлбөр”, “Эхийн эндэгдлийг бууруулах хоёр удаагийн стратеги” амжилттай хэрэгжсэний үр дүнд эх, нялхсын эндэгдэл буурч, 2013 онд 79371 эх амаржин, 100.000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 42.6 болсон байна.

Гэсэн хэдий ч 2013 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн 61131 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 766.2 ногдож байгаа ба нийт амаржсан эхтэй харьцуулан авч үзвэл 77.0% нь ямар нэг хүндрэлтэй төрж байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

Хүндрэлийг шалтгаанаар авч үзвэл:

- Жирэмсэн үеийн хүндрэл 35.6%
- Төрөх үеийн хүндрэл 50.6%
- Төрсний дараах хүндрэл 3.4%
- Жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл 10.4% -ийг эзэлж байна.

Мөн сүүлийн жилүүдэд бэлгийн замаар дамжих халдвар, ялангуяа тэмбүү өвчин ихсэж, ХДХВ/ДОХ-ын тохиолдол ч нэмэгдсээр байна. Тухайлбал: 2013 онд ХДХВ-ДОХ-ын 150 тохиолдол бүртгэгдсэний 23 тохиолдол нь тус онд шинээр нэмэгдсэн бол, бэлгийн замаар дамжих халдварын 14904 тохиолдол бүртгэгдсэний 41.9%-ийг тэмбүү өвчин эзэлж, 10000 хүн амд 22.2 ногдож байгаа ба төрөлхийн тэмбүүгийн 26 тохиолдол бүртгэгдсэн байна.

Энэ нь нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулах шаардлагатайг харуулсаар байгаа ба үүнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилт голлох байр суурьтай юм.

Энэ асуудал бодлогын түвшний анхаарлын төвд байж, нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний дөрөв дэх хөтөлбөр (2012-2016 он) хэрэгжин, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, ээлтэй орчин бүрдүүлэхэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтыг дэс дараатай нэмэгдүүлсээр байна.

Мөн зорилтыг хэрэгжүүлэх нэг үндсэн зарчим нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эмүүд болон жирэмслэлтээс хамгаалах эм, хэрэгслийг Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад оруулан, улсын бүртгэлд хамруулахад оршиж байна. 2009 онд батлагдсан Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн Үндэсний стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой хууль тогтоомжид, бодлогын судалгаа” хийхээр төлөвлөсөн байна.

Иймд стратегийн хэрэгжилтийг ханган, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн баримтын судалгаа хийж, шийдвэр гаргагчид, хэрэглэгчдийн нотолгоогоор хангах энэхүү ажлын үндэслэл болж байна.

Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

- НҮЭМ-ийн судалгаа -Үндэсний 2 удаагийн судалгаа.,
- Эх яагаад эндэв 200-2004 он, 2005-2007 он.,
- Эх нярайн эрүүл мэндийн ноцтой хүндрэл., 2010 он.,
- Үргүйдлийн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал.,
- Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээний стандартын үнэлгээ.,
- Эмэгтэйчүүдийн жирэмсэний хяналтын хамралт, тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээ.,
- Эх барихын яаралтай болон нярайн нэн шаардлагатай тусламжийн хэрэгцээ, үнэлгээ.,

- Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, бодлого шийдвэрийн өнөөгийн байдал, 2012 он
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж” үндэсний стратегийн хэрэгжилтийг дунд хугацааны үнэлгээ зэрэг цөөнгүй судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

**Судалгааны зорилго:** Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн судалгаа хийж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах

**Судалгааны зорилт:**

1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн судалгааг хийх
2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн өнөөгийн байдлын талаар шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах

**Судалгааны хүрэх үр дүн:**

- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой бодлого, хууль эрх зүйн судалгааны ажлын тайлан бичигдэн, дүгнэлт зөвлөмж гарна.

## 1.2. АРГАЧЛАЛ

**Судалгааны арга зүй:** Судалгаанд контент анализийн аргыг ашиглан, нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой эрүүл мэндийн бодлого, хууль эрх зүйн орчны болон бусад холбогдох баримт бичгийг авч үзлээ.

**Мэдээлэл цуглуулах, боловсруулах:** Судалгаа хийхдээ эх баримт бичгээс нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой тусгагдсан заалтуудыг түүвэрлэн, дүгнэлт хийлээ.

## ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭМ, ХЭРЭГСЛИЙН ХАНГАМЖ, ТҮГЭЭЛТ, САНХҮҮЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол улсын иргэн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, авах суурь эрхээ Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалуулдаг бол иргэн хүний эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулиар зохицуулдаг.

Энэхүү хуулинд зааснаар эрүүл мэнд гэдэг нь “Хүн өвчин эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлдэг” бол.,

Нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг нь “Хүний нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо, түүний үйл ажиллагаа хэвийн байх төдийгүй, бие махбод, оюун санаа, нийгмийн талаар бүрэн төгс эрүүл саруул”<sup>1</sup> байх тухай үгүүлдэг бөгөөд *эх нярайн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, аюултай үр хөндөлтөөс сэргийлэх, бэлгийн замаар дамжих халдвараас (ХДХВ/ДОХ-ыг оролцуулан) сэргийлэх гэсэн* таван үндсэн бүрэлдэхүүн хэсэг багтдаг.

Хүний эрүүл байх, эрүүл мэндээ хамгаалуулах суурь хэрэгцээг хангах, өөрөөр хэлбэл иргэний эрүүл мэнд, түүнчлэн нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих орчныг бүрдүүлэхэд эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилт чухал юм.

Бид энэхүү судалгаагаараа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилтийн бодлого, хууль, эрх зүйн орчин тус бүрээр нэг бүрчлэн авч үзэхийг хичээсэн болно.

<sup>1</sup> Хүн ам ба хөгжил олон улсын бага хурлаас баталсан хөтөлбөр, Кайр хот, 1994 он

## 2.1. БОДЛОГО

### 2.1.1. Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого-2008 оны 01 сарын 31-ны өдөр УИХ-аар баталсан.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого нь 2007-2015 онд Мянганы хөгжлийн зорилтыг хангах, эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихээр хоёр үе шаттайгаар авч үзсэн бодлогын гол баримт бичиг юм.

Энэхүү бодлогын баримт бичигт Монгол улсын хүн амын өсөлт удаан, наслалт харьцангуй богино, *нярай хүүхэд, эхийн эндэгдэл их*, хүн амын тоо цөөн байгаа нь хөгжлийн сул үзүүлэлт гэсэн байна.

Мөн Үндэсний хөгжлийн цогц бодлогод жендерийн тэгш байдлыг хангах, гэр бүл бат бэх байх, үр хүүхэд аюулгүй орчинд эрүүл өсөж, хөгжих бодлого баримтлахаар тусгасан нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэхүү баримт бичгийн эрүүл мэндийн хөгжлийн бодлого нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, өвчлөл эндэгдлийг тууштай бууруулж, хүн амын цэвэр өсөлт, дундаж наслалтыг дэмжих, *салбарын санхүүжилтийг оновчтой* болгоход чиглэж байна. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд 2 үе шаттай, стратегийн 6 зорилт дэвшүүлсэн байна.

Нэгдүгээр үе шатны стратегийн зорилт 4-т *эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоноглолын үйлдвэрлэлийн тэргүүлэгч технологийг хөгжүүлэхээр*;

Хоёрдугаар шатны стратегийн зорилт 2-т хүн амыг *аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангахаар* заасан байна.

Үүний тулд хүн амыг *зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр жигд хүртээмжтэй, тасралтгүй хангах*, эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, аюулгүй байдлыг хангах тогтолцоо бий болгохоор тусгайлан авч үзжээ.

*Эндээс харахад Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын стратегийн зорилтод аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоноглолын үйлдвэрлэлтэй болохоор заасан нь Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн эрх зүйн орчны нэг гол үндэслэл болж байна.*

### 2.1.2. Нийгмийн эрүүл мэндийн талаас төрөөс баримтлах бодлого-2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр, Монгол Улсын Их Хурлын 81 дугаар тогтоол

Энэхүү бодлого нь 2001 онд батлагдсан ба Монгол улсын Нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн ойрын 10-15 жилийн хугацаанд хэтийн чиглэлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг мөн.

Нийгмийн эрүүл мэндийн төрөөс баримтлах бодлогын 4.1.3-т Гэр бүл төлөвлөлт, эмэгтэйчүүд эсэн мэнд амаржих, өсвөр үеийг бэлгийн амьдралд бэлтгэх зэргээр нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартыг хангана гэж заасан байна. Энэ үйл ажиллагаатай холбоотой хангамж, түгээлт, санхүүжилтийн талаар тусгагдаагүй байна.

### 2.1.3. Эмийн талаар төрөөс баримтлах бодлого -2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр, Монгол Улсын Их Хурлын 68 дугаар тогтоол

Энэхүү бодлого нь 2002 онд батлагдсан ба Монгол улсын эм хангамжийн хэтийн чиглэлийг ойрын 10 жилийн хугацаанд тодорхойлсон үндсэн баримт бичиг мөн.

Энэхүү бодлогын эрхэм зорилго нь эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай, эм, биобэлдмэл хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, нэн шаардлагатай эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэж байна.

Тус бодлогын Эмийн *хангамж, үйлдвэрлэл, санхүүжилт* гэсэн хоёрдугаар хэсэгт:

- Хүн эмнэлэг, мал эмнэлгийн байгууллага нь эмчилгээ, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эмийг нэн тэргүүнд хэрэглэх<sup>2</sup>

<sup>2</sup> Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, 1/3

- Төрийн өмчийн эмнэлгүүдийг зайлшгүй шаардлагатай эмээр жигд тасралтгүй хангах зардлыг улсын төсвөөс олгох<sup>3</sup>
- Иргэний эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэнд зайлшгүй шаардлагатай зарим эмийг зохих хувиар хөнгөлөлттэй олгохыг дэмжих<sup>4</sup>
- Зайлшгүй шаардлагатай эмийн үнийг олон улсын жишигт үнийн хэмжээнд зохицуулах бодлого баримтлах<sup>5</sup>
- Улсын нөөцийн болон эмнэлгийн төлбөргүй тусламж, үйлчилгээний эмийн үнийг улсын төсвөөс санхүүжүүлэх<sup>6</sup>
- Төрийн болон хувийн хэвшлийн эм хангамжийн байгууллага нь хүн эмнэлэг, мал эмнэлгийн байгууллага болон хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр нэн тэргүүнд хангах чиглэл баримтлах<sup>7</sup>
- Орон нутгийн хүн амын зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, түгээлтийг жигд, хүртээмжтэй байлгахад төрөөс дэмжлэг үзүүлэх<sup>8</sup> ээр заасан байна.

Эмийн талаар төрөөс баримтлах бодлого нь Монгол улсын эм хангамжийн хэтийн чиглэлийг ойрын 10 жилийн хугацаанд тодорхойлсон, эмийн хангамж, үйлдвэрлэл, санхүүжилт, түгээлтийн талаарх үндсэн баримт бичиг боловч, хэрэгжилтийн хугацаа дууссан байна.

**Шигтгээ 1.** Энэхүү бодлогын хэрэгжилтэд ДЭМБ-ын байгууллагын аргачлалаар үнэлгээ хийсний үндсэн дээр эмийн талаар төрөөс баримтлах бодлогын шинэ төслийг Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 төслийн “Эмийн аюулгүй байдлын дээгдүмийг бэхжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийн зөвлөхүүдийн баг, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан ажлыг хэсэг хамтран боловсруулсан байна.

Эрүүл мэндийн сайд 2014 оны 04 сарын 16-ны өдөр “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын тогтоолын энэхүү төслийг УИХ-ын дарга З.Энхболдод өргөн барьжээ.

Эмийн талаар төрөөс баримтлах “Шинэ” бодлого батлагдсанаар эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт оновчтой болж, улмаар эмийн чанар, хангамж сайжран, төсвийн үр ашиг нэмэгдэнэ гэж үзсэн байна. Энэ бодлого нь 2014-2018 онд хэрэгжих юм байна.

<http://vip76.mn/content/23895>

#### **2.1.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого- 2014 оны 2 дугаар сарын 24-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 55**

Энэ бодлого нь 2014-2023 он хүртэл хэрэгжих урт хугацааны, эмнэлгийн тусламжийн хөгжлийн гол баримт бичиг юм. Энэхүү бодлого нь чанартай, аюулгүй, үр дүнтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээг залгамж чанартай, тасралтгүй тэгш, шудрага, чирэгдэлгүй үзүүлэхэд оршиж, иргэний эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцыг үе шаттайгаар өргөжүүлэхээр заасан байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилт болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр тухайлсан заалт байхгүй байна.

#### **2.1.5. Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого-2013 оны 05 сарын 13-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 176**

Энэ бодлого нь 2013-2023 онд хэрэгжих, эрүүл мэндийн технологийн хөгжлийн чиглэл болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөгжлийн түвшинг тодорхойлох үндсэн баримт юм. Бодлогын эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлогын бүтэц, зохион байгуулалт гэсэн хэсэгт эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр байгуулахаар заасан ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр тухайлсан заалт байхгүй байна.

<sup>3</sup> Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, 2/1

<sup>4</sup> Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, 2/2

<sup>5</sup> Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, 2/3

<sup>6</sup> Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, 2/4

<sup>7</sup> Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, 3/1

<sup>8</sup> Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, 3/2

## 2.2. ХУУЛЬ

### 2.2.1. Эрүүл мэндийн тухай хууль: 2011 оны 5-р сарын 5-ны өдөр УИХ-аар баталсан.

Эрүүл мэндийн тухай хуулиар:

- Эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр баталж, *санхүүжүүлэх*, хэрэгжилтэд хяналт тавих<sup>9</sup>
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний *санхүүжилтийн бодлогыг* тодорхойлох<sup>10</sup>
- Улсын төсвөөс *санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар*, өвчин, эмгэгийн жагсаалт, *санхүүжүүлэх арга, төлбөрийн хэмжээг тогтоох журмыг* холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлана<sup>11</sup>
- Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлэх, олсон орлогыг эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, *эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах*, засвар үйлчилгээ хийхэд зарцуулах бөгөөд уг орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлана<sup>12</sup>
- Жирэмсэн, төрөх, төрсний дараах 45 хоногт эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ<sup>13</sup> (*зөвхөн жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар*),-ний төлбөрийг төр хариуцахаар.,
- *Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл*, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, *ханган нийлүүлэх* үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлнэ<sup>14</sup> хэмээн тус тус зохицуулсан байна.

Эндээс дүгнэхэд энэ хуулиар Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр төлбөрийг төр хариуцах тусламж, үйлчилгээний жагсаалт, эм, эмнэлгийн хэрэгслийн санхүүжилт нь Эрүүл мэндийн болон Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар, Эм, эмнэлгийн хэрэгслийг хангах, түгээх (худалдах) нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан байгууллагаар дамжин тус тус хэрэгждэг байна.

### 2.2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль- 2005 оны 12 дугаар сарын 01-ны өдөр, УИХ-аар баталсан.

Энэхүү хуулиар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хуулиар тендер, тендерийн шалгаруулалт, босго үнэ, бараа, ажил үйлчилгээ, гэрээ байгуулах зэрэг нэр томъёоны тодорхойлолтыг хуульчилсан. Мөн худалдан авах ажиллагааны зарчим, худалдан авах ажиллагааны журам, нээлттэй тендер шалгаруулалтын журам зэрэг олон журам багтсан байна.

Хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай гэж үзсэн бол гэрээг шууд байгуулахаар хуульчилсан байна.

Хуулиар нөхөн үржихүйн эм, хэрэгслийг гэрээ байгуулан худалдан авах, зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах боломж нь нээгдэж, эмийн хангамжийг тогтвортой, найдвартай хангах эрх зүйн орчин бүрдсэн байна.

<sup>9</sup> Эрүүл мэндийн тухай хууль, 7 дугаар зүйл, 7.1.3

<sup>10</sup> Эрүүл мэндийн тухай хууль, 8 дугаар зүйл, 8.1.12.

<sup>11</sup> Эрүүл мэндийн тухай хууль, 24 дүгээр зүйл, 24.2.

<sup>12</sup> Эрүүл мэндийн тухай хууль, 24 дүгээр зүйл, 24.3.

<sup>13</sup> Эрүүл мэндийн тухай хууль, 24 дүгээр зүйл, 24.6.1

<sup>14</sup> Эрүүл мэндийн тухай хууль, 40 дүгээр зүйл, 40.1

**2.2.3.Эм, эмнэлгийн хэрэгслийн хууль: 2010 оны 06 сарын 27-ны өдөр УИХ-аар шинэчилсэн найруулгаар баталсан.**

Энэхүү хуулиар “Эм” гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэл зүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг буюу амьтан ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэгддэг бэлдмэлийг<sup>15</sup>.

“Эмнэлгийн хэрэгсэл” гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, сувилах болон бие махбодын бүтэц, үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигладаг туслах зориулалтын эд зүйлийг<sup>16</sup>.

“Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт” гэж хүн болон мал, амьтанд үзүүлэх эмнэлгийн тусламжид эн тэргүүнд хэрэглэхээр эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эм, эмнэлгийн хэрэгслийн нэрсийг<sup>17</sup>.

“Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр” гэж эмийн түүхий эд болон эмийн туслах бодис ашиглан эм зүйн технологийн дагуу эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг<sup>18</sup>

“Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага” гэж эмийн сан, эрүүл мэндийн байгууллага болон мал эмнэлгийг эм, эмнэлгийн хэрэгслээр бөөний үнээр хангах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг<sup>19</sup>  
Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн болон өнчин эмийн жагсаалтыг төрийн захиргааны холбогдох байгууллага батална<sup>20</sup>.

Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон эмийн үнийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно<sup>21</sup> гэж тус тус томъёолон, зүйлчилсэн байна.

Байгууллага, иргэн эм, эмнэлгийн хэрэгслийг гадаадаас тусламж, хандиваар авах тохиолдолд эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, хэрэглээ, түгээлтийн асуудлыг шийдвэрлэсэн<sup>22</sup> байхаар заажээ.

Мөн энэхүү хуулийн 6 дугаар зүйл: *Эм, эмнэлгийн хэрэгсэл*, биологийн идэвхит бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, *түгээлт*, хяналтын талаарх төрийн зохицуулалт гэсэн бүлэгт зайлшгүй шаардлагатай эмийн зохицуулалт, хяналтын хэрэгжилтийг төрөөс нэгдсэн зохицуулалтаар ханган, хэрэгжүүлэхээр заасан байна. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх Боомтыг Засгийн газар тогтоодог байна.

Мөн тус хуулийн 15.10 заалтад “Засгийн газраас баталсан жагсаалтын дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эмийн үйлдвэр, ханган нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулан дархлаажуулах бэлдмэл, эм, эмнэлгийн хэрэгслийг импортоор шууд нийлүүлэх эрхийг олгож болно” гэсэн чухал заалт нэмэгдсэн байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийг *түгээх* үйл ажиллагаа нь мөн тус хуулийн 16 дугаар зүйлээр зохицуулагдаж байна. Тухайлбал:

- Эмийн сангийн байршил, үйлчлэх хүрээг тухайн орон нутгийн онцлогт тохируулан тогтоох, эм эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохицуулах үүргийг нутгийн захиргааны байгууллага хүлээнэ<sup>23</sup>.
- Эмийн сан нь эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж төхөөрөмж болон биологийн идэвхит бүтээгдэхүүн, эрүүл мэнд, гоо сайхан, ариун цэврийн бүтээгдэхүүнээр үйлчилж болно<sup>24</sup>.

<sup>15</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 3.1.1

<sup>16</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 3.1.5

<sup>17</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 3.1.14

<sup>18</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 3.1.22

<sup>19</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 3.1.23

<sup>20</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 4.5

<sup>21</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 4.6

<sup>22</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 15.7

<sup>23</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 16.1

<sup>24</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 16.2

- Сумын багийн эмч орон нутгийн харьяаллын эмийн сангаас гэрээний дагуу авсан эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлэх хүрээнийхээ хүн амд үйлчилж болно<sup>25</sup> гэж тус тус хуульчилсан байна.

Эндээс харахад эрүүл мэндийн тухай хуульд нийцэн, нөхөн үржихүйн эм, хэрэгслээр **хангах, түгээх байгууллага** нь тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байгаа ба Засгийн газар зөвхөн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад орсон эмийн үнийн зохицуулалтад оролцдог. Харин бусад эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт байхгүй байна. Хөдөө, орон нутгийн хувьд нөхөн үржихүйн эм, эмнэлгийн хэрэгслээр хангах зохицуулалтыг нутгийн захиргааны байгууллага (аймгийн Эрүүл мэндийн газар) хүлээж, өрх, сум, багийн эмч нар харьяаллын дагуу эм, эмнэлгийн хэрэгслийг түгээдэг байна. Харин гадаадаас хандив, тусламжаар НҮЭМ-ийн эм, эмнэлгийн хэрэгсэл авсан тохиолдолд Эрүүл мэндийн яамтай урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр оруулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, эмийн сангаар түгээдэг байна.

**Шигтгээ 2.** Монгол улсад Буянт-Ухаа, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-үүд, Өлгий, Цагааннуур, Эрэнцавын боомтоор эм, эмнэлгийн хэрэгслийг нэвтрүүлж байна.

Гаалийн ерөнхий газрын мэдээллийн сайт, 2013 он


**Шигтгээ 3.** ЭМЯ-наас ОУ-ын зээл тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээн авах, хадгалах, түгээх, тээвэрлэх эм ханган нийлүүлэх байгууллагыг сонгон шалгаруулалтаар Монгол эмимпекс концерн хамтран ажиллаж, гэрээний дагуу нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийг хүлээн авах, орон нутагт тээвэрлэх, хадгалах, түгээх үйл явцыг хангаж ажилладаг байна.

“Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж” Үндэсний стратегийн дунд хугацааны үнэлгээний тайлангаас

**Шигтгээ 4.** 2013 оны байдлаар Монгол улсад 42 эмийн үйлдвэр, 128 эм ханган нийлүүлэх байгууллага, 789 эмийн санд нийт 5053 ажилтан, үүнээс 1288 эм зүйч, 1966 эм найруулагч ажиллаж байна.

Дүрслэл, хүснэгтээр эм ханган нийлүүлэх, түгээх байгууллага болон ажиллах хүчний 5 жилийн динамикийг улс, аймаг, Улаанбаатар хотоор үзүүлэв.  
Хүний нөөцийн байршил, хангамжийн судалгаа, ЭМХТ, 2013 он


**ДҮРСЛЭЛ 1. ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА, АЖИЛЛАХ ХҮЧИН**




<sup>25</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 16.3



**ДҮРСЛЭЛ 2. ЭМИЙН ҮЙЛДВЭР, АЖИЛЛАХ ХҮЧИН**



**ДҮРСЛЭЛ 3. ХУВИЙН ЭМИЙН САН, АЖИЛЛАХ ХҮЧИН**



**ХҮСНЭГТ 1.ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ, ТҮГЭЭХ БАЙГУУЛЛАГА БА АЖИЛЛАХ ХҮЧИН (2013 ОН)**

	Аймгийн нэр	Эм ханган нийлүүлэх байгууллага	Эмийн үйлдвэр	Хувийн эмийн сан
<b>Байгууллагын тоо</b>				
1	Архангай	1	0	12
2	Баян-Өлгий	3	0	9
3	Баянхонгор	3	0	15
4	Булган	2	0	25
5	Говь-Алтай	1	0	3
6	Говьсүмбэр	0	0	7
7	Дархан-Уул	0	0	54
8	Дорноговь	3	0	15
9	Дорнод	1	0	11
10	Дундговь	2	0	8
11	Завхан	0	0	11
12	Орхон	6	0	39
13	Өвөрхангай	4	0	33
14	Өмнөговь	3	0	30
15	Сүхбаатар	1	0	11
16	Сэлэнгэ	1	0	46
17	Төв	0	0	10
18	Увс	5	0	12
19	Ховд	4	0	12
20	Хөвсгөл	6	0	35
21	Хэнтий	3	0	18
22	Улаанбаатар	79	42	373
	<b>Улсын дүн</b>	<b>128</b>	<b>42</b>	<b>789</b>
<b>Ажиллах хүчин</b>				
1	Эм зүйч	158	48	1082
2	Эм найруулагч	192	64	1710
	<b>Улсын дүн</b>	<b>350</b>	<b>112</b>	<b>2792</b>

#### **2.2.4. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль -2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, УИХ-аар баталсан.**

Манай улсад хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолтой гэж бүртгэгдсэн иргэд нь бэлгийн замаар халдвар авсан байна. Иймд уг хуулийг авч үзсэн болно.

Энэхүү хуулиар хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа, эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн, иргэн, аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлж, уг вирусийн халдвар авсан буюу дархлал олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Энэхүү хуулийн дагуу нутгийн өөртөө удирдах байгууллага нь уг вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх үйл ажиллагаанд шаардагдах *эдийн засаг, санхүү*, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна<sup>26</sup> гэсэн байна.

*Хуулиар харьяаллын дагуу нутгийн өөртөө удирдах байгууллага ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр байна.*

**Шигтгээ 5.** Монгол улсад ХДХВ/ДОХ-той 177 хүн бүртгэгдсэний 81.4% нь эрэгтэй, 18.6% нь эмэгтэйчүүд байгаа ба 21 хүн нас барсан байна. 2014 онд 27 хүн шинээр бүртгэгдэн, 2 хүн нас баржээ.

*Эрүүл мэндийн үзүүлэлт, 2013 он*

#### **2.2.5. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль- 2002 оны 04 сарын 25-ны өдөр, УИХ-аас баталсан.**

12 дугаар зүйл: Даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр:

- 7.6. Өрх, сум, багийн эмнэлэгт бүртгэлтэй даатгуулагч өрх /сум, баг/-ийн эмчийн жороор зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан эмийг эмийн сангаас худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ.
- 12.9. Энэ хуулийн 7.6-д заасан хөнгөлттэй олгох эмийн жагсаалт, уг эмийн үнийн даатгалын сангаас олгох хувь, хэмжээг даатгалын зөвлөл баталж, нийтэд мэдээлнэ гэж хуульчилсан байна.

*Энэхүү хууль нь Нийгмийн Даатгалын Үндэсний зөвлөлөөс нөхөн үржихүйн чиглэлээр үнийн хөнгөлт үзүүлэх эмийн жагсаалт, хувь хэмжээг тогтоон батлах, мөн өрх, сум, багийн эмчийн жороор нөхөн үржихүйн эм, хэрэгсэл түгээгдэх эрх зүйн гол үндэслэл болж байна.*

**Шигтгээ 6.** Жирэмслэлтээс сэргийлэх таван төрлийн эм хэрэгслийг эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтад оруулсан. Ингэснээр жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн зах зээлийн үнэ бараг 57-83 хувиар буурч, иргэдийн дунд жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийн хүртээмж нэмэгдлээ.

*НҮБ-ын Хүн амын сангийн тайлан, 2013 он*

### **2.3. СТРАТЕГИ**

#### **2.3.1.Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж Үндэсний стратеги- 2009 оны 06 сарын 17-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 185**

Энэхүү стратеги нь аюулгүй, чанарын баталгаатай жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэл, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн бусад нэн шаардлагатай эм, багаж хэрэгслээр хэрэглэгчид тасралтгүй хангагдан, хүссэн газраасаа, сонголт хийх, авах боломжийг хангахад чиглэсэн үндсэн баримт бичиг юм.

Энэхүү стратегид зааснаар манай орны нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгсэлд *эх барих, нярайн яаралтай нэн шаардлагатай эм хэрэгслүүд, бэлгийн замаар дамжих халдвар болон*

<sup>26</sup> Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 6.1

Хүний дархлал хомсдолын вирусын халдварын оношлуур, урвалж, нэн шаардлагатай эмүүд, жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэл хамаарч байна.

Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийг сайжруулахад:

- Эм, хэрэгслийг оновчтой сонгох
- Хэрэгцээг зөв тооцох
- Боломжийн үнээр худалдан авах
- Горимын дагуу зөв хадгалах
- Хугацаанд зөв хүргэх
- Зөв зохистой хэрэглэх гэсэн үндсэн 6 зарчим байдаг байна.

Стратегийн зорилго нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй, баталгаатай, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх, Хангамжийн Удирдлага, Мэдээллийн Тогтолцоог бүрдүүлэх, найдвартай ажиллагааг хангахад оршиж байна.

Энэхүү стратегийн **Зорилт 1-д**:

- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй тогтвортой хангамжийн үйл ажиллагааг эмийн талаар төрөөс баримтлах бодлого, эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө, бусад хөтөлбөр, төсөв, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, эмийн эргэлтийн сангийн статус, эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар оролцоог нэмэгдүүлэх.;
- *Малчид, ядуу иргэдэд жирэмслэхээс сэргийлэх, бэлгийн замаар дамжих халдварыг оношлох, эмчлэх эм, хэрэгслийг үнэ төлбөргүй олгох* арга хэмжээг шийдвэрлэх зэрэг өргөн хүрээний агуулга багтсан байна.

Мөн энэ зорилтын хүрээнд:

- Шийдвэр гаргагчдын дэмжлэгт орчинг бүрдүүлэх
- Засгийн газар, хувийн хэвшил, олон улсын болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангасан байнгын ажиллагаатай зохицуулах механизмыг бүрдүүлэх
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг хувийн эм хангамжийн болон төрийн бус байгууллагуудаар ханган нийлүүлэх, боломжийн үнээр түгээх
- НҮБ-ын Хүн амын сангийн Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тогтвортой байдлыг хангах дэлхийн хөтөлбөр болон бусад олон улсын байгууллагатай энэ чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэхээр заасан байна.

**Зорилт 2-т** Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн санхүүжилтийн найдвартай эх үүсвэрийг бий болгон, хэрэгцээг тооцох, худалдан авах, хадгалах, түгээх, мэдээлэх, чанарын баталгааг хангах тогтолцоог бүх түвшинд бүрдүүлж чадавхийг бэхжүүлэхээр заажээ.

Энэ хүрээнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн худалдан авалтын нэгдсэн тогтолцоог бий болгох, хангамжийн удирдлага мэдээллийн цахим тогтолцоог бүрдүүлэх, шаардлага хангасан агуулахтай болох, хэрэгцээг тооцон, өртөг зардлыг тооцох зэрэг асуудлууд багтсан байна.

Мөн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх хүрээнд:

- Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эм хэрэгсэл.;
- Бэлгийн замаар дамжих халдварыг эмчлэх эмийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх.;
- Амбулаториор үзүүлж буй нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ, түүний дотор жирэмсэний хяналт, бэлгийн замаар дамжих халдвар, нөхөн үржихүйн үрэвсэлт өвчнүүдийн эм хэрэгслийн зардлын тодорхой хэсгийг Эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлдэг болохоор заасан байна.

**Зорилт 3-т** Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлнэ гэсэн байна. Энэ хүрээнд 2015 он гэхэд хандивлагчдаас хамааралгүйгээр Үндэсний хэмжээнд нөхөн үржихүйн эм, хэрэгслээр бүрэн хангах зорилтыг тавьсан байна. Үүний тулд:

- 2009-2012 онд шаардлагатай эм, хэрэгслээр хэтийн тооцооны дагуу жил тутам нэгдсэн журмаар нийлүүлэх.;
- Аймаг, нийслэлийн амаржих газар, тасаг, алслагдсан сум, сум дундын эмнэлгүүдийг эх барих, нярайн яаралтай тусламжийн нэн шаардлагатай эм багаж, тоног төхөөрөмжөөр стандартын дагуу үе шаттай хангах.;
- Жирэмслэлтээс сэргийлэх зарим эм, хэрэгслийг нийгмийн зах зээлээр болон эмийн эргэлтийн сангаар дамжуулан түгээх хөтөлбөрийг өргөжүүлэх.;

- Гамшиг болон хямралын үед онц шаардлагатай нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, төлөвлөлтөд тусгахаар стратегийн чиглэлийг тогтоосон байна.

Үндэсний стратегийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээг 2011 онд, төгсгөлийн үнэлгээг 2013 онд шалгуур үзүүлэлтийн дагуу хийж, цаашид үргэлжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ гэсэн байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтэд 19 шалгуур үзүүлэлт багтсан байна. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь 3 зорилтын хүрээнд 47 ажлыг 10,067 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Энэхүү стратегийн баримт бичиг нь Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжүүлэлтийн гол эрх зүйн баримт бичиг мөн.*

*Энэхүү стратеги батлагдсанаар эх барих, нярайн яаралтай тусламжийн нэн шаардлагатай эм хэрэгслүүд, жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгслүүд, бэлгийн замаар дамжих халдвар болон хүний дархлал хомсдолын вирусын халдварын оношлуур, урвалж, нэн шаардлагатай эмүүдийн хангамж, түгээлт, санхүүжилтэд төр, төрийн бус байгууллага болон НҮБ-ын хүн амын сан, бусад олон улсын байгууллагууд хамтран оролцох эрх зүйн орчин бүрдсэн байна.*

*Мөн жирэмсэн, төрөх, төрсөний дараах үеийн тусламж, үйлчилгээний эм хэрэгслийн зардлыг төр үргэлжлүүлэн санхүүжүүлэхээр тусгасан нь эрүүл мэндийн тухай хуулийн “Жирэмсэн, төрөх, төрсний дараах 45 хоногт эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээний төлбөрийг төр хариуцахаар заасантай нийцэж байна.*

*Малчид ядуу иргэдийн бэлгийн замаар дамжих халдварыг эмчлэх эмийн зардлыг төсөвт тусгах, шаардлагатай урвалж, оношлуураар хангах, эмийн эргэлтийн сангийн оролцоог хангах эрх зүйн орчин бүрдүүлэх зэрэг хангамж, түгээлттэй холбоотой чухал алхамууд төлөвлөгдсөн байна. Стратегийн хэрэгжилтэд 2013 онд төгсгөлийн үнэлгээг хийж, цаашид үргэлжүүлэх эсэхийг шийднэ гэсэн байна.*

**Шигтгээ 7.** ЭМЯ-аас 2012 оны 12 сард хийж, 26 эрүүл мэндийн байгууллага, 32 эмийн санг хамруулан хийсэн байна.

Үнэлгээгээр Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын ХАС-ийн Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн тогтвортой байдлыг хангах дэлхийн хөтөлбөр болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажилласнаар Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хангахын тулд чанарын баталгаатай нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангах үндэсний чадавхийг бүрдүүлэхэд ихээхэн ахиц гаргасан гэж дүгнэсэн байна.

*Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж Үндэсний стратегийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээний тайлан, 2012 он*

**Шигтгээ 8.** Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж Үндэсний стратегийн хэрэгжилтийг хангахад зориулан 2009 онд анх удаа улсын төсөвт НҮЭМ-ийн эм, хэрэгсэлд 85 сая, 2010 онд 100 сая, 2011 онд 150 сая, 2012 онд 150 сая төгрөгний санхүүжилтийг төлөвлөн зарцуулсан байна.

*Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж Үндэсний стратегийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээний тайлан, 2012 он*

**Шигтгээ 9** Монгол Улсын Засгийн Газар нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгсэлд зориулсан төсвөө нэмэгдүүлэн, 2014 онд урд оноос бараг 50 хувиар өсч, 83,000 ам. доллараас 124,000 ам. доллар болон нэмэгдсэн ба эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний цэгүүдийн бараг 40 хувь нь жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслээр үнээгүй үйлчилж байна.

НҮБ-ын Хүн амын сангийн тайлан, 2013 он

### **2.3.2. Эх, нярайн эрүүл мэнд стратеги-2010 оны 12 сарын 28-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 456**

Энэхүү стратеги нь Эрүүл эхээс эрүүл хүүхэд гэсэн уриан дор эх нярайн өвчлөл, эндэгдлийг тогтвортой бууруулахад чиглэн, 3 үндсэн зорилт дэвшүүлэн, хүлээгдэж буй үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон байна.

Энэхүү стратегийн Зорилт 2-ын хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2-т:

- НҮЭМ-ийн эм, эмнэлгийн хэрэгслээр тогтвортой хангах нөхцөл бүрдэх;<sup>27</sup>
- Эх барих, нярайн яаралтай тусламжинд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр бүх шатлалын эмнэлгүүдийг тасралтгүй хангах.,<sup>28</sup>
- Эх, нярайн эмнэлгийн тусламжид шаардагдах нэг удаагийн хэрэгслээр бүрэн хангах<sup>29</sup>-аар тус тус заан, 2011-2015 онд хэрэгжүүлэх 65 үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

Мөн энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, түншлэгчдээс НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Глобал сан, Азийн хөгжлийн банк, Люксембургийн Засгийн газар, Норвегийн тусламжийн байгууллагыг цохон дурдсан бөгөөд, НҮБ-ын Хүүхдийн санг санхүүжилт, хэрэгжилт, хангамж, хяналт үнэлгээнд дэмжлэг үзүүлэхээр тусгасан байна. Стратегийн шалгуур үзүүлэлт болон зайлшгүй хэрэгжүүлэх үйл ажиллагааны үнэлгээнд НҮЭМ-ийн эм, хэрэгсэлтэй холбоотой үзүүлэлт байхгүй байна.

*Энэхүү стратеги нь эх, нярайн тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эх барих, нярайн тусламжийн тоног төхөөрөмж, жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслийг олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрөө хангах гол эрх зүйн үндэслэл болжээ.*

*Харин эх нярайн яаралтай тусламжийн болон НҮЭМ-ийн эм, эмнэлгийн хэрэгслээр бүх шатлалын эмнэлгүүдийг тогтвортой, тасралтгүй хангах үйл ажиллагааны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт тодорхой бус байна.*

**Шигтгээ 10.** Эх барих, нярайн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, нийгмийн халамж, дэмжлэг тусалцаа шаардлагатай иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор жирэмслэхээс хамгаалах эм хэрэгсэл, нөхөн үржихүйн зайлшгүй шаардлагатай эм, эх барих, нярайн тусламжийн тоног төхөөрөмжийг ЭМЯ-ны захиалгын дагуу НҮБ-ын ХАС нийлүүлж ирсэн бөгөөд эдгээр тоног төхөөрөмж нь эх, нярайд үзүүлэх тусламжийн чанар, үйлчилгээг сайжруулах, хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

*Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж Үндэсний стратегийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээний тайлан, 2012 он*

<sup>27</sup> Эх, нярайн эрүүл мэнд стратегийн зорилт 2, хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.7

<sup>28</sup> Эх, нярайн эрүүл мэнд стратегийн зорилт 2, хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.5

<sup>29</sup> Эх, нярайн эрүүл мэнд стратегийн зорилт 2, хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.6

### **2.3.3. Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, тандах дэлхийн стратеги, 2006-2015 он**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Бэлгийн замаар дамжих, халдвараас сэргийлэх, тандах дэлхийн стратегийг 2006-2015 онд хэрэгжүүлэхээр батлан гаргасан.

Энэхүү стратеги нь техникийн болон мэдээлэл, сургалт, сурталчилгаа гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэж байна. Техникийн хэсэгт бэлгийн аюулгүй зан үйлийг дэмжих, үр дүнтэй хүртээмжтэй тусламж үзүүлэх, хяналтыг сайжруулах аргууд багтаж байна. Мэдээлэл сургалт сурталчилгааны хэсэгт улс төрийн оролцоог дэмжих, хөтөлбөрийн удирдагчдад зориулсан зөвлөмжийг санал болгосон байна.

Стратегийн үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ гэсэн бүлэгт: Үндэсний хэмжээнд ач холбогдол өгч буй үр дүнд тулгуурласан үйл ажиллагааг тооцоолсоны үндсэн дээр *төсөв хөрөнгийг дайчлах, нөөцийг ахин хуваарилах* асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ гэсэн байна.

### **2.3.4. Төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх Үндэсний стратеги 2010 оны 12 сарын 29-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 458**

Энэхүү стратеги нь бэлгийн замаар дамжих халдварын тусламж, үйлчилгээг нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээтэй уялдуулах, эх нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахтай уялдан, эхээс хүүхдэд тэмбүүгийн халдвар дамжихаас сэргийлэх зорилгоор жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү өвчинг эрт илрүүлэн, төгс эмчилж, төрөлхийн тэмбүү өвчнөөс урьдчилан сэргийлэхийг зорьсон байна.

Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны Зорилт 1-ийн хүрээнд:

- Тэмбүүгийн халдвар илрүүлэх урвалж бодис, багаж тоног төхөөрөмж, эмийн хангамж нь олон улсын дэмжлэгтэйгээр төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр хангагдаж байгааг цаашид улсын төсөвт үе шаттай тусган, төрөөс санхүүжилтийг нэмэгдүүлэхээр тусгасан байна.

Стратегийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд төрөлхийн тэмбүүтэй тэмцэх үйл ажиллагаанд төрөөс зарцуулсан санхүүжилт 10 хувиар нэмэгдсэн байна гэсэн боловч суурь үзүүлэлт тодорхой бус, нөгөө талаас эмийн хангамжийг улсын төсвөөс хэрхэн санхүүжүүлсэнийг үнэлэх шалгуур байхгүй байна.

Харин стратегийг хэрэгжүүлэх 25 үйл ажиллагаа төлөвлөсөн ба эм урвалж бодисоор хангах үүргийг ЭМЯ хүлээн, хамтран ажиллах байгууллага нь Глобал сангийн ХДХВ/ДОХ/ Сүрьеэгийн төсөл, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар байхаар төлөвлөн, 2013-2015 онд 268,837,000 төгрөг төсөвлөжээ.

*Эндээс дүгнэхэд төрөлхийн тэмбүү өвчнийг илрүүлэх эм, урвалжийн хангамж нь олон улсын, тухайлбал Глобал сангийн дэмжлэгээр санхүүжиж байгаа ба цаашид улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.*

**Шигтгээ 11.** 2013 оны байдлаар аймагт 12, Улаанбаатар хотод 14, бүгд 26 төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрсөний 3 нь нас барсан байна.

Төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх зорилгоор "Жирэмсэн эмэгтэйн тэмбүү өвчнийг эрт оношлох, эмчлэх" журмыг Эрүүл мэндийн сайдын 2011 оны 11 сарын 01-ны өдрийн 350 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн үзүүлэлт, 2013 он

### **2.3.5. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратеги- 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 84**

Энэхүү стратеги нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулахыг зорьсон байна.

Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.2.3-т Эрэгтэйчүүдийн кабинетуудыг нэн шаардлагатай багаж хэрэгсэл, эм, оношлуулаар хангах ажлыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөсөн ба нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой асуудал тусгагдаагүй байна.

*Шигтгээ 12. 2013 оны байдлаар эрэгтэйчүүдийн дундаж наслалт 64.42 байгаа нь эмэгтэйчүүдээс 10.59-өөр бага юм.*

*Энэ онд амбулаториор түрүү булчирхайн өвчнөөр 2664, эр бэлэг эрхтний бусад өвчнүүдээр 1500 эрэгтэйчүүд хандсан бол тэмбүү өвчнөөр 2215, заг хүйтэн өвчнөөр 2422 хүн, трихомониаз өвчнөөр 589 эрэгтэйчүүд өвчилсөн байна.*

*Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл-II боть, 2013 он*

### **2.3.6. Эх, хүүхдийн бичил тэжээлийн дутлаас сэргийлэх стратеги-2005 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 85**

Энэхүү стратегийн зорилго нь бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн зарим амин дэм, эрдэс бодисын хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

Стратегийн зорилт 5.3-т зорилтот бүлгийн хүн ам, ялангуяа тусламж, үйлчилгээ хүртэж чадахгүй байгаа хүн амыг *А ба Д амин дэм, төмрийн бэлдмэлээр хангах, санхүүгийн тогтвортой механизм* бүрдүүлэхээр заасан байна.

Энэ хүрээнд 0-5 насны хүүхэд, хөхүүл эхчүүд, жирэмсэн эмэгтэйчүүдийг засгийн газар, олон улсын байгууллагын дэмжлэг, санхүүжилтээр бичил бодисоор зорилтод бүлгийг хангаж байгаа ба стратегийн эцсийн шатны үнэлгээг 2015 онд хийх юм.

### **2.3.7. Хуурамч эмтэй тэмцэх Үндэсний стратеги – 2010 оны 07 сарын 22-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын тушаал, дугаар 269**

Энэхүү стратегийн зорилго нь эмийн талаар мөрдөх хууль, эрх зүйн орчин, лабораторын хүчин чадлыг сайжруулах, олон нийтэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг олгох, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн боловсронгуй болгох замаар зах зээлд хуурамч эм болон стандартын бус эм нэвтрэхээс сэргийлэхэд оршиж байна.

Энэ стратегид нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн талаар онцгойлон дурдаагүй боловч, нөхөн үржихүйн эм хэрэгсэл хуурамчаар орж ирэхээс сэргийлэх эрх зүйн үндэслэл болж байгаагаараа уялдаж байна.

### **2.3.8. ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх Үндэсний стратеги- 2010 оны 2 дугаар сарын 17-ны өдөр, Засгийн газрын 43 дугаар тогтоол**

Энэхүү стратегийн хүрээнд 7 зорилт дэвшүүлсэн ба зорилт 5-д ХДХВ, БЗДХ-ын хяналт, сэргийлэлтэд шаардлагатай санхүүгийн тогтвортой нөөц бүхий хууль эрх зүйн болон нийгмийн бодлогын дэмжлэгт орчин бий болгож бэхжүүлэхээр заасан байна. Эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой тухайлсан заалт байхгүй байна.

## **2.4. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

### **2.4.1. Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний 4 дэх хөтөлбөр- 2012 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн Засгийн газрын тогтоол, дугаар 61**

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих замаар монгол хүний хөгжлийг хангах таатай орчин бүрдүүлж, Мянганы хөгжлийн зорилтыг хангахад оршиж байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, ээлтэй орчин бүрдүүлэхэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээг дэс дараатай нэмэгдүүлж 2016 он гэхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг төрөөс бүрэн санхүүжүүлж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн болон өсвөр насныханы хэрэгцээтэй эм хэрэгслээ боломжийн үнээр авах нөхцөлийг хангах<sup>30</sup> -аар заажээ.

*Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагааны нэгдүгээр зорилтын хүрээнд:*

- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн зарим төрлийн тусламж, үйлчилгээ болон эм хэрэгслийг 2016 он гэхэд төрөөс бүрэн санхүүжүүлэх арга хэмжээг шат дараатай авах<sup>31</sup>-аар.,

*Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагааны тавдугаар зорилтын хүрээнд:*

4.5.2. Шинээр баригдах Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, амаржих газрууд, төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эх, нярайн тусламж, үйлчилгээнд хэрэгцээтэй, чанарын шаардлага хангасан эмнэлгийн тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, эх нярайн нэг удаагийн цомгоор бүрэн хангах арга хэмжээг дэс дараатай авах.,

4.5.3. Жирэмслэхээс хамгаалах орчин үеийн нэн шаардлагатай эм, хэрэгсэлд зарцуулах улсын төсвийг дэс дараатай нэмэгдүүлэх.,

4.5.4. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эмүүд болон жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслийг Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад оруулах, улсын бүртгэлд бүрэн хамруулах .,

4.5.5. Зах зээл дэх жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслийн нэр төрлийг олшруулж, чанар, аюулгүй байдлыг хангах.,

4.5.6. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслээр хангахад төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын оролцоог хангах, хөдөө орон нутагт жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгслийг нийгмийн зах зээлээр түгээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх

4.5.7. Өрх, сум, аймгийн эмнэлэгт нөхөн үржихүйн замын үрэвсэлт өвчнийг оношлох, эмчлэх чадавхийг сайжруулж, шаардагдах эм, хэрэгсэл, оношлуулаар тасралтгүй хангах Энэхүү хөтөлбөрийн:

- 4.3.4-т өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн, тогтолцооны эмгэг, архаг өвчнийг илрүүлж, нарийн мэргэжлийн болон холбогдох салбарын оролцоотойгоор эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар тусгасан байна. Харин өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндэд зориулсан эм, хэрэгслийн талаарх онцгойлсон заалт байхгүй байна.

Эндээс дүгнэхэд манай улсын нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, санхүүжилтийн гол бодлого нь 2016 он гэхэд засгийн газраас бүрэн санхүүжүүлэх, улмаар нөхөн үржихүйн эрүүл мэндэд төрөөс зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн, санхүүжүүлэлтийн тасралтгүй тогтвортой байдлыг бий болгож, нэр төрлийг нэмэгдүүлэн, найдвартай эх үүсвэрээс хангахад чиглэж байна.

**Шигтгээ 13.** НҮЭМ-ийн Үндэсний 3 удаагийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд НҮБ-ын Хүн амын сангаас НҮЭМ-ийн эм, хэрэгсэлд 994,756,35 ам долларын санхүүжилт, Азийн хөгжлийн банкнаас 4 сая гаруй ам.доллар, Люксембургийн Засгийн газраас 1 сая гаруй ам доллар, НҮБ-ийн Хүүхдийн сангийн “Эх нярайн эрүүл мэнд” төслийн хүрээнд 500 гаруй ам доллар, ДЭМБ-аас 250 мянга гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийж, тодорхой ахиц, дэвшил гарсаныг тэмдэглэсэн байна.

*“Нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний V дугаар хурлын илтгэлээс*

**Шигтгээ 14.** НҮЭМ-ийн Үндэсний 3 удаагийн хөтөлбөр хэрэгжих хугацаанд Монгол улсын засгийн газраас жирэмслэхээс хамгаалах хэрэгсэл, эхийн эрүүл мэндэд зориулсан эм, хэрэгслийн улсын төсвийг 46 хувиар нэмэгдүүлсэн байна. 1992 оноос эхлэн жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн 90 гаруй хувийг НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр үнэ төлбөргүй олгож ирсэн ба сүүлийн 5 жилд бэлгэвчийн 60 гаруй хувийг, БЗДХ/ХДХВ-ын халдварын оношлуурын дийлэнх хувийг Глобал сан, НҮБ-ын Хүн амын сангаас хангасан байна.

*Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний гуравдах хөтөлбөрийн үнэлгээний тайлангаас*

<sup>30</sup> Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр, зорилт 2.2.5

<sup>31</sup> Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр, нэгдүгээр зорилт 4.1.2



## **2.4.2. Эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр- 2010 оын 10 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын тогтоол, дугаар 268**

Эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр нь монгол улсад хэрэгжиж байгаа 10 гаруй үндэсний хөтөлбөрийг дэд хөтөлбөр шинжтэйгээр багтаасан, эрүүл мэндийн урт хугацааны стратегийн зорилтыг тодорхойлсон хөтөлбөр юм.

Хөтөлбөрийн зорилго нь Монгол улсын хүн амын эрүүл мэндийг сайжруулж, өсөлтийг дэмжих, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг олон улсын жишигт дүйцүүлэн хүргэх, хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлснээр эдийн засгийн хөгжлийг дэмжихэд оршиж байна.

Хөтөлбөрийн стратегийн зорилтын 3-т: Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай *эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслээр жигд хүртээмжтэй* хангахаар.,

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд, Хүн амын хэрэгцээг тооцох аргачлал боловсруулж, эм ханган нийлүүлэлтэд мөрдүүлнэ гэсэн байна. Энэ хөтөлбөрт нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгсэлтэй холбоотой шууд утгаар орсон заалт, үйл ажиллагаа байхгүй байна.

## **2.5. БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЖУРАМ, ШИЙДВЭР**

### **2.5.1. Удирдамж, журам батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2012 оны 02 сарын 27-ны өдөр, 63 дугаар тушаал**

Энэхүү тушаалын:

- Нэгдүгээр хавсралтаар “Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний удирдамж”-ийг.,
- Хоёрдугаар хавсралтаар “Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн тогтвортой байдлыг хангах журам”-ыг .,
- Гуравдугаар хавсралтаар “Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргын иргэдэд үнэ төлбөргүй олгох журам”-ыг тус тус баталсан байна.

#### **2.5.1.1. Гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний удирдамж:**

Энэхүү удирдамжаар гэр бүл төлөвлөлтийн үр дүнтэй үйлчилгээний шинж чанар, зөвлөгөө өгөх удирдамж өгсөн байна.

Мөн удирдамжаар жирэмслэлтээс хамгаалах дааврын хавсарсан эм, дан прогестерон агуулсан эм, яаралтай ууж жирэмслэлтээс хамгаалах эм, жирэмслэхээс хамгаалах прогестрон агуулсан тариа, суулгац, зэс агуулсан ерөндөг, даавар агуулсан ерөндөг, хавсарсан даавар агуулсан наалт, үтрээний цагираг, сарын тариа, эрэгтэй бэлгэвч, эмэгтэй бэлгэвч, жирэмслэхээс хамгаалах хаалтын аргууд, эрэгтэй үрийн суваг боох, эмэгтэйн хүсэлтээр үр дамжуулах хоолойг боох гэсэн 15 бүлэг удирдамж багтсан байна.

*Шигтгээ 15. 2013 оны байдлаар нөхөн үржихүйн 15-49 насны 1000 эмэгтэй тутмын 552 нь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэг арга хэрэглэдэг байна. Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглээний бэлгэвч 32.4%-ийг, ерөндөг 25.5%-ийг, эм бэлдмэл 24.4%-ийг, тариа 11.4%-ийг, умайн дамжуулах суваг боох 1.4%-ийг, суулгац 0.3-ыг тус тус эзэлж байна.*

*Эрүүл мэндийн үзүүлэлт, 2013 он*

#### **2.5.1.2.Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн тогтвортой байдлыг хангах журам:**

Монгол Улсын Засгийн газрын болон НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эм, хэрэгслийн хангамжийн удирдлага, мэдээллийн тогтолцооны үйл ажиллагаа энэ журмаар зохицуулагдаж байна. Энэхүү журмыг анхан болон хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүд мөрдөж ажиллах юм.

Анхан шатанд асуудал хариуцсан мэргэжилтэн жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгсэл болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хэрэгцээг тооцоолон захиалга

хийнэ. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагч удирдлага, арга зүйгээр бүрэн хангаж, эм хэрэгслийг хүлээн авах, түгээх, тайлагнах, хяналт тавих чиг үүргийг хүлээнэ.

Үндэсний түвшинд жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор орон нутгаас ирүүлсэн захиалгыг нэгтгэн дүгнэж, улсын хэмжээний хэрэгцээг тооцон, эм хэрэгслийг түгээх хуваарийг гарган, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулдаг.

Хүргэх, түгээх, тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааг Эрүүл мэндийн сайдын 2011 оны 105 дугаар тушаал “Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журмын дагуу ЭМЯ-тай түншлэлийн гэрээ байгуулсан гэрээт байгууллага гүйцэтгэнэ.

### **2.5.1.3. Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргын иргэдэд үнэ төлбөргүй олгох журам:**

“Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”, “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж” үндэсний стратегийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас санхүүжүүлж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргын иргэдэд үнэ төлбөргүй олгох үйл ажиллагаа нь энэхүү журмаар зохицуулагдаж байна.

#### **Энэхүү журмын “Үндэсний түвшинд эм, хэрэгслийг захиалах, хүлээн авах, хадгалах, түгээх” гэсэн хэсэгт:**

- Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хэрэгцээг нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдийн судалгааг үндэслэн гаргах
- Шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, батлуулах
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийг худалдан авах ажиллагааг Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулж, хуваарийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах
- Эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг ханган нийлүүлэгчид хүргүүлэхдээ гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвар, эм, хэрэгслийн чанарын баталгаажилт хийлгэх төлбөрийг тооцоолон зардалд тусгасан байх
- Эм, хэрэгслийг, орон нутагт тээвэрлэн хүргэх асуудлыг Эрүүл мэндийн яамтай стратеги түншлэлийн гэрээ байгуулсан эм ханган нийлүүлэх байгууллагаар гүйцэтгүүлэхээр тус тус оруулсан байна.

#### **Энэхүү журмын Орон нутгийн түвшинд эм, хэрэгслийг захиалах, хүлээн авах, хадгалах, түгээх гэсэн гуравдугаар хэсэгт:**

- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч нь тухайн сум, хорооны ядуу, өрх толгойлсон, олон хүүхэдтэй, нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг эмэгтэйчүүдэд шаардагдах жирэмлэхээс сэргийлэх эм хэрэгслийн хэрэгцээг тооцож, захиалгыг ЭМГ-т 7 дугаар сарын 5, 12 дугаар сарын 15 –ны дотор хүргүүлнэ.
- Аймаг, нийслэлийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагч нар орон нутгийн түвшинд эм, хэрэгслийн нэгдсэн захиалгыг жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны дотор боловсруулж, Channel программд оруулсан байна. (Засгийн газар, НҮЭМ-ийн төсөл гэж ялгахгүй)
- Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан хуваарийн дагуу орон нутагт нийлүүлэгдсэн эм, хэрэгслийг Эм бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- Орон нутагт эм, хэрэгслийг нэгж, салбаруудад хуваарилах, хадгалах, түгээх, мэдээлэх, сурталчлах болон ядуу, малчин, өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүд, нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд хүргэх, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газар зохион байгуулна.
- Хүлээн авсан эм, хэрэгслийг харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлэгт хуваарилах асуудлыг аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- ЭМГ-ын даргын тушаалаар хуваарилсан эм, хэрэгслийг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, эмийн эргэлтийн сангийн эрхлэгч эсвэл эх баригч бага эмч зэрэг итгэмжлэгдсэн төлөөлөгч баримтын дагуу нэг бүрчлэн тоолон хүлээж авна.

- Эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд олгох ажлыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн кабинетийн эмч, сувилагч нар гардан гүйцэтгэнэ.
- Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд үнэ төлбөргүй олгоно.
- Нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд олгосон эм, хэрэгслийн бүртгэлийг хөтөлж, улирал, жилээр дүнг нэгтгэнэ.
- Нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд олгосон эм, хэрэгслийн анхан шатны бүртгэл нь НҮБ-ын ХАС-гаар нийлүүлэгдсэн жирэмслэхээс хамгаалах эм хэрэгслийн бүртгэлтэй ижил байх бөгөөд Засгийн газрын санхүүжилтээр олгож байгааг тодотгосон байна.
- Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газраас эм, хэрэгслийн зарцуулалтын тайланг тухайн жилийн 7 дугаар сарын 5, 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж, ЭМЯ-ны Эм эмнэлгийн хэрэгслийн хэлтэст мэдээлж байна гэж тус тус заажээ.

*Эндээс харахад “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”, “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж” үндэсний стратегийн хэрэгжилт хангагдан, нийгмийн эмзэг давхаргын иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг үнэ төлбөргүй олгох үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэн байна.*

*Энэхүү эм хэрэгслийг Үндэсний түвшинд захиалах, худалдан авах эрх, үүргийг ЭМЯ хүлээж, хадгалах, түгээх, орон нутагт тээвэрлэн хүргэх асуудлыг эм ханган нийлүүлэх байгууллага гэрээгээр хариуцан, анхан шатны болон нэгдсэн эмнэлэгт хувиарлах, түгээх асуудлыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хариуцаж байна.*

### **2.5.2. Импорт, экспортын лиценз олгох журам, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 343 тоот тушаал**

Энэхүү журмын дагуу Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эмийг импортоор оруулдаг.

Энэхүү журмын 1.7-д Гадаадын улс орны Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгж, олон улсын болон буяны байгууллагаас хандив, тусламжаар ирж буй эм, эмнэлгийн хэрэгсэл нь Эрүүл мэндийн сайдын 105 тоот тушаалаар батлагдсан “Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам”-д заасан шаардлагыг хангасан байна хэмээн журамласан байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамжид НҮБ-ын хүн амын сан, Глобал сан нь голлох үүргийг гүйцэтгэж ирсэн байна.

### **2.5.3. Төлбөрийг төр хариуцах тусламж, үйлчилгээний тухай-Эрүүл мэндийн сайдын 2006 оны 12 сарын 05-ны өдрийн 393 дугаар тушаал.**

Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар төлбөрийг төр хариуцах журмыг, хоёрдугаар хавсралтаар төлбөрийг төр хариуцах тусламж, үйлчилгээний жагсаалтыг, гуравдугаар хавсралтаар төлбөрийг төр хариуцах эмийг олгох журмыг дөрөвдүгээр хавсралтаар төлбөрийг төр хариуцах эмийг олгох хуудасны загварыг тус тус баталсан.

Төлбөрийг төр хариуцах тусламж, үйлчилгээний жагсаалтад Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр **эх барих, нярайн тусламж**, үйлчилгээний төлбөрийг төр хариуцахаар орсон байна.

Мөн эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төр хариуцдаг ба энэхүү тусламж, үйлчилгээний нэг бүрэлдэхүүн хэсэг нь гэр бүл төлөвлөлт, НҮЭМ-ийн талаарх мэдээлэл, сургалт сурталчилгаатай холбоотой асуудлууд хамаардаг.

Монгол улсын эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан, 2012 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 129/100 дугаар тушаалаар, 2006 оны 393 тушаалын гурав, дөрөвдүгээр хавсралт хүчингүй болсон.

**Шигтгээ 16.** *Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Амаржих газрууд 2010 онд 11,4 тэрбум , 2011 онд 14.9 тэрбум, 2012 онд 20.6 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ.*

*Эвүүл мэндийн яам. төсвийн гүйцэтгэлийн тайлан*

#### **2.5.4. Төлбөрийг төр хариуцах эмийг олгох журам- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан, 2012 оны 4 сарын 20-ны өдрийн 129/100 дугаар тушаал**

Энэхүү журмаар төлбөрийг төр хариуцах эмийг олгох журам, төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалтыг тус тус баталсан. Энэхүү журам, жагсаалтаар дархлалын олдмол хомсдол өвчний үед хэрэглэх *ацикловир, зидовудин, ламивудин* гэсэн 3 нэр төрлийн шахмал, капсул бүхий бэлдмэл орсон байна.

#### **2.5.5. Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 105 дугаар тушаал**

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15.8 дугаар заалтыг хэрэгжүүлэх, гадаадын хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, ашиглалтыг сайжруулах зорилгоор батлагдсан.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн шугамаар нийлүүлэгдэж байгаа эм, хэрэгслийн нийлүүлтэд энэхүү журмыг мөрддөг ба эм, эмнэлгийн хэрэгслийг гаалийн агуулахаас татах, түгээх үүргийг сонгон шалгаруулалтад тэнцсэн ЭМЯ-тай гэрээ байгуулсан байгууллага гүйцэтгэдэг. Эрүүл мэндийн яам импортын лиценз олгодог байна.

#### **2.5.6. Журам батлах тухай- Эрүүл мэндийн сайдын 2012 оны 07 сарын 05-ны өдөр, дугаар 42**

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15.8 дугаар заалтыг хэрэгжүүлэх, Монголын Мянганы сорилтын сангийн Эрүүл мэнд төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлсэн эмийн зохицуулалт, ашиглалтыг сайжруулах зорилгоор уг тушаал батлагдсан.

Энэхүү журмын дагуу төслийн хүрээнд *умайн хүзүү болон хөхний өмөн*, артерийн даралт ихдэлт, чихрийн хэв шинж-2 зэрэг зонхилон тохиолддог халдварт бус өвчнүүдийн эрт илрүүлгийн үзлэг, эмчилгээний хүрээнд нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнийг чанартай эм, хэрэгслээр хангана гэж заасан.

Журмын дагуу буцалтгүй тусламжаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт шалгарсан эм ханган нийлүүлэх байгууллага гэрээний дагуу нийлүүлэн, чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцдаг.

Эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах, хадгалах, түгээх ажлыг аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн болон сумын эмийн эргэлтийн сангийн эрхлэгч, өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан гүйцэтгэдэг.

Нэгдсэн удирдлагаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар ажилладаг эм, хэрэгслийг нийгмийн халамж, дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд оношилгоо, эмчилгээний заалтаар үнэ төлбөргүй олгодог.

#### **2.5.7. Үр хөндөлтийг зохицуулах журам- Эрүүл мэндийн сайдын тушаал, 2010 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр, дугаар 105**

Энэхүү журам нь Эрүүл мэндийн тухай хуулийн 36.2, Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ MNS 5488:2005 Монгол улсын стандартыг хэрэгжүүлэн, үр хөндөлтийг зохицуулахад чиглэсэн. Журамд нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгсэл, санхүүжилттэй холбоотой заалт тусгагдаагүй байна.

**Шигтгээ 17.** 2013 оны байдлаар 15628 үр хөндөлт бүртгэгдсэний 6.2%-ийг 20-оос доош насныхан эзэлж, 1000 амьд төрөлтөд 195.0, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 18.5 үр хөндөлт ногдож байна. Үр хөндөлт Улаанбаатар хотод улс, аймгийн дунджаас өндөр байна.

Энvvп мэндийн vзvvлэлт. 2013 он

#### **2.5.8. Амин чухал, эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаал**

Энэхүү журмаар амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн журам, эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг баталсан. Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад нийт 50 нэр төрлийн эм, хэрэгсэл орсон байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр **окситоцин** орсон байна. Журмын дагуу бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга нар амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийг төсөвт өртөгтөө багтаан худалдан авч, тогтмол хоёр сарын нөөцтэй байлгах үүргийг хүлээдэг.

### **2.5.9. Жагсаалт шинэчлэн батлах тухай-Эрүүл мэндийн сайдын 2014 оны 215 дугаар тушаал**

Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжийг сайжруулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор зайлшгүй шаардлагатай эмийн 7 дах жагсаалт шинэчлэгдэн батлагдсан.

Журмаар эмийн хангамжийг сайжруулах чиг үүргийг эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн дарга, захирал, эрхлэгч хүлээж байгаа ба журмыг 2015 оны 1 сараас эхлэн мөрдөнө.

*Энэхүү шинэ жагсаалтад 29 бүлгийн 500 гаруй зайлшгүй шаардлагатай эм, бэлдмэл орсоноос нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр жирэмслэлтээс сэргийлэх 7 төрлийн эм, бэлдмэл, үр тогтоолтыг дэмжих 4 эм, бэлдмэл, эр бэлгийн дааврын 2 эм, бэлдмэл, өндгөвчний даавар, шар биеийн даавар, окситоцин болон умай агшаах бэлдмэл, окситоцины эсрэг умайн булчин сулруулах эм зэрэг нийт 24 нэр төрлийн эм, бэлдмэл оржээ.*

*Жагсаалтын 18. 29.1-т нярайд хэрэглэх эм-хлоргексидин, каффейн, ибупрофен, простогландин, сурфактант, нярайн эхэд хэрэглэх эм дексаметазон гэсэн 6 нэр төрлийн эм, бэлдмэл шинээр орсон байна.*

### **2.5.10. Эмийн эргэлтийн сангийн журам, эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаал**

Энэхүү журам нь сум, багийн түвшинд эмийн хангамжийг тогтвортой байлгах зорилгоор батлагдсан. Эмийн эргэлтийн сан нь орон нутгийн өмчид суурилсан хуулийн этгээд юм.

Журмын дагуу эмийн эргэлтийн сан нь зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр сумын эрүүл мэндийн төв, хүн амыг тасралтгүй хангаж, эмийн хангамж 90-ээс доошгүй хувьтай байна гэж заасан. Энэ заалт нь нөхөн үржихүйн эм, хэрэгсэлд хамааралтай заалт юм.

*Эмийн эргэлтийн сан нь хөдөөгийн хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийг захиалах, хадгалах, түгээхэд голлох үүргийг гүйцэтгэдэг.*

**Шигтгээ 18.** Эмийн эргэлтийн сан нь анх 1994-2004 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 17 аймгийн 285 суманд байгуулагдаж байсан ба 2010 онд Төв аймгийн 26 сум эмийн эргэлтийн сантай болсоноор 311 болж, үйл ажиллагаагаа явуулж байна.

[www.moh.mn](http://www.moh.mn)

### **2.5.11. Жагсаалт батлах тухай- Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2013 оны 07 сарын 31-ны өдрийн 28 дугаар тогтоол**

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 5.2.2, 7.6, 12.9 дэх заалт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, нэр төрөл, хөнгөлөх хувь хэмжээг өөрчилсөн байна. Энэхүү жагсаалтад 21 бүлгийн 134 нэр төрлийн эм багтсан байна.

Жагсаалтын 16 бүлэг: даавар, дотоод шүүрлийн булчирхайн бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл гэсэн хэсгийн:

16.2 Жи­рэм­слэлтээс сэргийлэх хэрэгсэл:

16.2.1. Дааврын бэлдмэл

16.2.2. Цэвэршилтийн эсрэг бэлдмэл

16.4. Үр тогтолтыг сэдээх бэлдмэлийг тус тус оруулсан байна.

Тус жагсаалтад этинилэстрадиол+левоноргестрел, этинилэстрадиол ципротероны ацетат, этинилэстрадиол+ левоноргестрел+ төмрийн фумарат дроспиренон+ этинилэстрадиол, левоноргестрел гэсэн 5 нэр төрлийн дааврын бэлдмэл, эстроген+прогестаген цэвэршилтийн эсрэг бэлдмэл, кломифен үр тогтолтыг сэдээх бэлдмэл, нийт 7 нэр төрлийн эм бэлдмэлд эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх юм.

#### **2.5.12. Эх, нярайн тусламж, үйлчилгээний хяналтын хуудас батлах тухай- Эрүүл мэндийн сайдын 2012 оны 07 сарын 09-ны өдөр, 256 дугаар тушаал**

Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилт, Эх нярайн эрүүл мэнд стратегийн 3.22 дугаар заалтыг хэрэгжүүлэх, эх нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор, эх нярайн хяналтын хуудсыг батлан гаргасан.

Энэхүү хяналтын хуудас нь 48 бүлэг, ангилал бүхий 1100 гаруй шалгуур үзүүлэлттэй өргөн хүрээний агуулгыг багтаасан хяналтын хуудас юм. Энэ хуудсаар “Гэр бүл төлөвлөлтийн эм, хэрэгсэл”, “Төрөх өрөөний нэн шаардлагатай эмийн хяналтын хуудас”, Жирэмсэний болон яаралтай тусламжийн өрөөний багаж, тоног төхөөрөмжийн хяналтын хуудас”, “Эмээр үр хөндөх хяналтын хуудас” тус тус багтаж байна.

Тухайлбал, гэр бүл төлөвлөлтийн хяналтын хуудсанд эрэгтэй, эмэгтэй бэлгэвч, жирэмслэлтээс хамгаалж уух эм, жирэмслэлтээс хамгаалж яаралтай уух эм, жирэмслэхээс хамгаалах тариа, суулгац, умайн ерөндөг, шийдвэр гаргах арга хэрэгсэл буюу товхимол орсон байна.

#### **2.5.13. Удирдамж батлах тухай- Эрүүл мэндийн сайдын 2010 оны 04 сарын 27-ны өдрийн 156 дугаар тушаал:**

Энэхүү тушаалаар 5 аймгийн 6 сумын эрүүл мэндийн төв, 5 сум дундын эмнэлгийг Нөхөн үржихүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний загвар эмнэлэг болгохоор баталсан.

Тушаалын хоёрдугаар хавсралтаар загвар сумын эмнэлгийн удирдамжийг баталсан ба эмнэлгийн зорилго, стратеги, удирдлага зохион байгуулалт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хангамжийн удирдлага, мэдээллийн тогтолцоо, хяналт үнэлгээ гэсэн 6 үндсэн бүлгээс бүрдэж байна.

Удирдамжийн 3.3.2-ийн *санхүүжилт* гэсэн хэсэгт:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын өртгийг тооцох арга хэрэгсэлийг эзэмшиж, сумынхаа НҮЭМ-ийн тусламж үйлчилгээ, эм хэрэгсэлд шаардагдах зардлыг тооцож, төсөв төлөвлөгөө хийхдээ ашиглах,
- Эх барихын яаралтай тусламжийн болон жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн хангамжийг тогтвортой, хүртээмжтэй байлгахын тулд хэрэгцээг зөв тооцож, жил бүр эм, эмнэлгийн хэрэгслийн тендерт оруулж байхаар орсон байна.

#### **2.5.14. Нярайн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тухай- Эрүүл мэндийн сайдын 2008 оны 01 сарын 04-ны өдөр, 02 тоот тушаал**

Нярайн зайлшгүй шаардлагатай тусламжийн зарчим, нярай хүүхдийг шилжүүлэх, тээвэрлэхэд баримтлах зарчим, *жирэмсэн эхэд фолийн хүчил, төмрийн бэлдмэл нэмэлтээр өгөх зарчим*, жирэмсэн эхчүүдийг ураг оношлогооны шинжилгээнд хамруулах, нярайн цогц тусламж үйлчилгээ үзүүлэх нэгжийг байгуулах тухай баталсан.

*Энэ тушаалын 5 дугаар хавсралтаар өсвөр насны охид, жирэмслэхээр төлөвлөж буй эмэгтэйчүүд, жирэмсэн эмэгтэйд төмрийн бэлдмэл, фолийн хүчил нэмэлтээр хэрэглэх тун хэмжээг заасан байна. Хаанаас хэрхэн түгээх талаар тусгаадаагүй байна.*

### **2.6. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИ- МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

Стандартчилал, тохиролын үнэлгээний тухай Монгол улсын хуулийн 6.5-д заасны дагуу:

- Стандартчиллын техникийн хорооны хэлэлцэж, дэмжсэн стандартын төслийг Стандартчиллын Үндэсний хорооны зөвлөл улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч, Үндэсний стандартаар баталдаг.

2012 оны 2 сарын 1-ны байдлаар Үндэсний стандартын бүртгэлд 6000 гаруй стандарт бүртгэгдсэнээс эрүүл мэндийн салбарт 1000 гаруй стандарт мөрдөгдөж байна. Үүний 34.9%-ыг оношилгоо, эмчилгээний, 30.9%-ыг эмийн хэрэгслийн стандарт эзлэж байна. Үндэсний стандартаас Нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой, хүчин төгөлдөр стандартыг шүүн авч үзлээ.

**2.6.1. Монгол улсын стандартын дугаараар ангилсан жагсаалт, 11.200 Төрөхийн хяналт. Жирэмслэлтээс хамгаалах механик арга:**

- MNS 5256:2003 Ургийн бойжилт удаашрах хам шинжийн чанд авиан шинжилгээ
- MNS 5258:2003 Ураг ихсийн хэвийн үзүүлэлтийн чанд авиан шинжилгээ
- MNS 5259:2003 Хэт залуу ба ахимаг настай тулгартөрөгч эмэгтэй жирэмслэлт ба төрлөгийг удирдах
- MNS .ISO 4074-1:2001 Резинэн бэлгэвч. 1-р хэсэг: Техникийн ерөнхий шаардлага
- MNS .ISO 4074-2:2001 Резинэн бэлгэвч. 2-р хэсэг: Уртыг тодорхойлох
- MNS .ISO 4074-3:2001 Резинэн бэлгэвч. 3-р хэсэг: Өргөнийг тодорхойлох

**2.6.2. Монгол улсын стандартын дугаараар ангилсан жагсаалт, 11.020 Эрүүл мэндийн шинжлэх ухаан ба эмнэлгийн тусламжийн нийтлэг асуудал:**

- MNS 5203:2002 Эрүүл хамгаалах технологи- Кесеров хагалгааны мэс засал
- MNS 5287:2003 Умайн лейкомиомын оношилгоо, эмчилгээ
- MNS 5348-49:2003 Хүний дархлал хомсдолын вирусын халдварт өвчний тархвар судлалын тандалт
- MNS 5348-50:2003 Бэлэг эрхтний хомхой өвчний тархвар судлалын тандалт
- MNS 5348-51:2003 Тэмбүү өвчний тархвар судлалын тандалт
- MNS 5348-52:2003 Заг хүйтэн өвчний тархвар судлалын тандалт
- MNS 5348-53:2003 Хламид өвчний тархвар судлалын тандалт
- MNS 5348-54:2003 Трихомониаз өвчний тархвар судлалын тандалт
- MNS 5348-55:2003 Зөөлөн яр өвчний тархвар судлалын тандалт
- MNS 5855-1:2010 Өндгөвчийн хорт хавдрын оношилгоо, эмчилгээ
- MNS 5855-2:2010 Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ
- MNS 5855-3:2010 Гадна бэлэг эрхтний хорт хавдрын оношилгоо, эмчилгээ
- MNS 5855-4:2010 Умайн их биеийн хорт хавдрын оношилгоо, эмчилгээ,
- MNS 5855-5:2010 Үтрээний хавтгай хучуур ба булчирхайлаг эдээс гаралтай хорт хавдрын оношилгоо, эмчилгээ
- MNS 5861:2011 Хөхний өмөнгийн эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ
- MNS 5944:2008 Түрүү булчирхайн хорт хавдрын оношилгоо, эмчилгээ
- MNS 5945:2008 Эр бэлэг эрхтний хорт хавдрын оношилгоо, эмчилгээ
- MNS 5948:2008 Төмсөгний хорт хавдрын оношилгоо, эмчилгээ

**2.6.3. Монгол улсын стандартын дугаараар ангилсан жагсаалт, 11.100 Эмнэлгийн лаборатори:**

- MNS 5456-20:2005 ХДХВ/ДОХ өвчний лабораторын оношилгооны техникийн шаардлага
- MNS 5456-21:2003 Бэлгийн хомхойн лабораторын оношилгооны техникийн шаардлага
- MNS 5456-22:2003 Тэмбүүгийн лабораторын оношилгооны техникийн шаардлага
- MNS 5556-23:2003 Заг хүйтэн өвчний лабораторын оношилгооны техникийн шаардлага
- MNS 5556-24:2003 Хламидын лабораторын оношилгооны техникийн шаардлага
- MNS 5556-25:2003 Трихомониазын лабораторын оношилгооны техникийн шаардлага

#### **2.6.4. Монгол улсын стандартын дугаараар ангилсан жагсаалт, 11.120. Эм зүй:**

Энэхүү бүлгийн 11.120.01. Эм зүйн нийтлэг асуудал гэсэн ангилалд 23 стандарт багтсанаас эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрлэлд тавигдах нийтлэг шаардлагууд багтсан байна.

Энэ бүлгийн 11.120.10. Эмийн хэрэгсэл гэсэн ангилалд 318 стандарт багтсан ба дотроо ямар нэг ангилал байхгүй ба, шүүн тунгааваас нөхөн үржихүйн эрүүл мэндтэй шууд холбоотой эмийн хэрэгсэл байхгүй байна.

*Нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой халдварт, халдварт бус өвчний оношилгоо, эмчилгээний Үндэсний стандартад тус бүрдээ тухайн өвчинд хэрэглэгдэх эм, хэрэгслийг заалтаар тусгадаг.*

*Эндээс дүгнэхэд Монгол улсын эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи-Монгол улсын стандартад Нөхөн үржихүйн эрүүл мэндтэй шууд холбоотой төрөхийн хяналт, жирэмслэлтээс хамгаалах механик аргатай холбоотой 6 стандарт, оношилгоо, эмчилгээний 18 стандарт, лабораторын техникийн шаардлагын 6, нийт 30 стандарт батлагдсан байна. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой тухайлсан стандарт байхгүй байна.*

#### **ХЭЛЦЭМЖ**

*Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилтийн бодлого, эрх зүйн орчны судалгаанд 5 бодлого, 5 хууль, 7 стратеги, 2 үндэсний хөтөлбөр, 13 журам, шийдвэр, 4 тусламж, үйлчилгээний технологи, нийт 37 эрх зүйн баримтыг онцгойлон судлав.*

*Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн тэргүүлэгч технологийг хөгжүүлэн, аюулгүй, чанарын баталгаатай эм, хэрэгслээр жигд, хүртээмжтэй тасралтгүй хангахаар заасан нь Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн эрх зүйн орчны гол үндэслэл болсон байна.*

*Монгол улсын эмийн талаар төрөөс баримтлах бодлогын хэтийн төлөвийн хугацаа дууссан, дараагийн шинэчлэлийн үе шатанд ирсэн байна.*

*Эрүүл мэндийн тухай хуулиар нөхөн үржихүйн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, импортлох, ханган нийлүүлэх болон төлбөрийг төр хариуцах тусламж, үйлчилгээний жагсаалт, санхүүжилт нь Эрүүл мэндийн болон Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн тушаалаар шийдвэрлэхээр эрх зүйн орчин бүрдсэн байна.*

*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль нь Нөхөн үржихүйн эм хэрэгслийг худалдан авахад захиалагч талтай гэрээ байгуулах эрх зүйн үндэслэл болж байна.*

*Эм, эмнэлгийн хэрэгслийн хуулиар Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслээр хангах, түгээх байгууллага нь тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байхаар, орон нутгийн захиргааны байгууллага нь зохицуулалтаар хангаж ажиллахаар байна. Энэ хуулиар сумын багийн эмчийг онцгойлон авч үзэн, гэрээний дагуу эм, хэрэгслээр үйлчлэх хүрээний хүн амд үйлчлэх эрхийг өгсөн байна.*

*Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулиар зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон эмийг, эмийн сангаас худалдан авсан тохиолдолд хөнгөлөлт үзүүлэхээр хуульчилсан ба 2015 онд мөрдөгдөх Зайлшгүй шаардлагатай эмийн 7 дах жагсаалтад нөхөн үржихүйн 7 нэр төрлийн эм, бэлдмэл орсон байна.*

*“Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн Үндэсний стратеги” нь Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангамж, түгээлтийн гол, үндсэн эрх зүйн баримт бичиг болж байна.*

*Энэхүү стратегийн хүрээнд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эм хэрэгслүүдийн хангамж, түгээлт, санхүүжилтэд төр, төрийн бус байгууллага болон НҮБ-ын хүн амын сан, бусад олон улсын байгууллагууд хамтран оролцох, төлбөрийг төр хариуцан санхүүжүүлэх зэрэг гол эрх зүйн орчин бүрдсэн байна. Стратегийн хэрэгжилтэд 2013 онд төгсгөлийн үнэлгээг хийсэн ба цаашид түвшин ахисан шинэ стратеги шаардлагатай байна.*



Эх, нярайн эрүүл мэнд стратегт Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлын талаар тодорхой заалтууд тусгагдсан боловч хэрэгжилтийг хэрхэн хангах шалгуурууд тодорхой бус байна. 2015 онд хэрэгжилт дуусна.

Төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх Үндэсний стратеги нь олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр санхүүждэг ба цаашид төрөөс үе шаттайгаар санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогыг баримталсан байна.

“Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Хуурамч эмтэй тэмцэх”, ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх Үндэсний стратегиудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгсэл, түгээх, хангах, санхүүжүүлэх талаар онцгойлсон заалт байхгүй байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний 4 дэх хөтөлбөрт нөхөн үржихүйн эм, хэрэгслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг онцгойлон авч үзэн, 2016 он гэхэд төрөөс бүрэн санхүүжүүлэхээр тусгасан байна. Үүний тулд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эмүүд болон жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслийг Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад оруулах, улсын бүртгэлд бүрэн хамруулахаар заажээ.

Энэхүү бодлого, хууль, стратеги, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн цөөнгүй журам, шийдвэр гарсан байна.

Энэхүү журмуудаар нөхөн үржихүйн эм, хэрэгслийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн эмзэг давхаргын иргэдэд нөхөн үржихүйн эм, хэрэгслийг үнэ төлбөргүй олгох, нөхөн үржихүйн эм, хэрэгслийг хадгалах, түгээх, орон нутагт тээвэрлэн хүргэх, төлбөрийг төр хариуцах эмийг олгох, импортлох, хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах, амин чухал, эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний 1000 гаруй стандартын 30.9% нь эмийн хэрэгслийн стандарт байна. Үүнээс жирэмслэлтээс хамгаалах арга техникийн 6 стандарт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр эмчилгээ, оношилгоотой холбоотой 18 стандарт, лабораторын шинжилгээтэй холбоотой 6 стандарт, эм зүйтэй холбоотой 2, нийт 30 стандарт хэрэгжиж байна.

## ДҮГНЭЛТ

1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилтийн хангалттай эрх зүйн орчин бүрдсэн байна.
2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслээр **хангах, түгээх** чиг үүргийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан эм хангамжийн байгууллагууд, эмийн сангууд хүлээж байна.
3. Энэхүү эм хэрэгслийг Үндэсний түвшинд захиалах, худалдан авах эрх, үүргийг ЭМЯ хүлээж, эрүүл мэндийн байгууллагад хувиарлах асуудлыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хариуцдаг тогтолцоотой байна.
4. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр төлбөрийг төр хариуцах тусламж, үйлчилгээний жагсаалт, эм, эмнэлгийн хэрэгслийн **санхүүжилт** нь Эрүүл мэндийн болон Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар батлагдаж байна.
5. Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэн 2016 он гэхэд төрөөс бүрэн санхүүжүүлэхээр бодлого, стратегийн баримт бичгүүдэд тусгасан байна.
6. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон эм, бэлдмэлд үнийн хөнгөлөлт үзүүлдэг эрх зүйн орчин бүрдэж, 2015 оноос нөхөн үржихүйн 7 нэр төрлийн эм, бэлдмэлд үнийн хөнгөлөлт үзүүлэх юм байна.
7. Монгол улсын эмийн талаар төрөөс баримтлах бодлогын хөгжлийн шинэчлэлийн үе шатанд ирсэн байна.
8. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлийн бодлого, хууль эрх зүйн орчинд нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн түгээлт, хангамж, санхүүжилтийн талаар нэг санаа, нэг утга агуулга олонтоо давтагдаж байна.

## ЗӨВЛӨМЖ

1. Монгол улсын эмийн талаар төрөөс баримтлах хөгжлийн чиг хандлагыг тогтоосон “Шинэ бодлого”-ыг батлуулах
2. “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн Үндэсний стратегийн төгсгөлийн үнэлгээ, Шинэ бодлогод суурилсан “Шинэ стратеги”-ийг гаргах, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан бусад эрх зүйн орчнуудыг нэгтгэн, шинэчлэх
3. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн санхүүжилт шинэ шатанд гарч, төрөөс 100.0 хувь санхүүжиж эхлэх хугацаа (2016 он) ойртсонд дүн шинжилгээ хийж, эрсдлийг тооцоолох
4. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний үндсэн бүрэлдэхүүн болох аюултай үр хөндөлтөөс сэргийлэх, үргүйдлийн тусламж, үйлчилгээний бодлого, стратегийн эрх зүйн орчин дутмаг, эм хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилтийн талаар тусгайлсан бодлого, стратеги байхгүй байгааг бодлогын түвшинд анхааралдаа авах
5. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратегид эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар тусгагдаагүйд анхаарлаа хандуулан, бусад бодлого, эрх зүйн орчинд тусгах

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### БОДЛОГО

- Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн
- цогц бодлого
- Нийгмийн эрүүл мэндийн талаас төрөөс баримтлах бодлого
- Эмийн талаас төрөөс баримтлах бодлого
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого
- Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого

### 2.2.ХУУЛЬ

- Эрүүл мэндийн тухай хууль
- Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хууль
- Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай

### 2.2. СТРАТЕГИ

- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж Үндэсний стратеги
- Эх, нярайн эрүүл мэнд стратеги
- Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, тандах дэлхийн стратеги
- Төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх Үндэсний стратеги
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратеги
- Эх, хүүхдийн бичил тэжээлийн дутлаас сэргийлэх стратеги
- Хуурамч эмтэй тэмцэх Үндэсний стратеги
- Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги
- Бөөр хамгаалах үндэсний стратеги

### 2.3. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

- Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний 4 дэх хөтөлбөр
- Эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр
- Халдварт өвчинтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр

### 2.4. БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЖУРАМ, ШИЙДВЭР

- Удирдамж, журам батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2012 оны 63 дугаар тушаал:
  - Гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний удирдамж.,
  - Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн тогтвортой байдлыг хангах журам.,
  - Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргын иргэдэд үнэ төлбөргүй олгох журам.,
- Импорт, экспортын лиценз олгох журам
- Төлбөрийг төр хариуцах тусламж, үйлчилгээний тухай
- Төлбөрийг төр хариуцах эмийг олгох журам

- Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам
- Журам батлах тухай, 2012 оны, 42 дугаар тушаал
- Үр хөндөлтийг зохижуулах журам
- Амин чухал, эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам
- Жагсаалт шинэчлэн батлах тухай, 2014 оны 215 тушаал
- Эмийн эргэлтийн сангийн журам
- Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2013 оны 28 дугаар тогтоол
- Эх, нярайн тусламж, үйлчилгээний хяналтын хуудас батлах тухай- 2012 оны 256 дугаар тушаал<sup>2</sup>
- Нярайн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тухай
- Эмийн бүртгэлийн журам
- Тусгай зөвшөөрөл олгох журам

### **ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИ- МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

- Монгол улсын стандартын дугаараар ангилсан жагсаалт, 11.200 Төрөхийн хяналт. Жирэмслэлтээс хамгаалах механик арга
- Монгол улсын стандартын дугаараар ангилсан жагсаалт, 11.020 Эрүүл мэндийн шинжлэх ухаан ба эмнэлгийн тусламжийн нийтлэг асуудал
- Монгол улсын стандартын дугаараар ангилсан жагсаалт, 11.100 Эмнэлгийн лаборатори
- Монгол улсын стандартын дугаараар ангилсан жагсаалт, 11.120. Эм зүй

#### **Бусад:**

- Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний дах хөтөлбөрийн үнэлгээний тайлан
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж Үндэсний стратегийн үнэлгээний тайлан
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд судалгааны тайлангууд
- Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, бодлого шийдвэрийн өнөөгийн байдал, 2012 оны судалгааны тайлан
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн байршил, хангамж, 2014 оны судалгааны тайлан
- НҮБ-ын Хүн амын сангийн 2013 оны үйл ажиллагааны тайлан
- “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний V дугаар хурлын илтгэл
- Эрүүл мэндийн үзүүлэлт, 2013 он
- 2013 оны Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл –II, IV боть
- Эхийн эндэгдлийг бууруулах зарим арга хэмжээний тухай, ЭМС-ын тушаал
- Эхийн амрах байрны бүтэц, үйл ажиллагаа, ЭМС-ны тушаал
- Эх, нярайн эрүүл мэндийн итгэмжит лавлагаа” судалгааны дэвшилтэт аргыг нэвтрүүлэх тухай, ЭМС-ын тушаал
- Эх, нялхаст ээлтэй эмнэлэг үйл ажиллагааны хүрэх түвшин, үнэлгээний аргачлалыг батлах тухай, ЭМС-ын тушаал
- “Нярайн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тухай, ЭМС-ын тушаал
- Жирэмсэн эмэгтэйн тэмбүү өвчнийг эрт оношлох, эмчлэх журам, ЭМС-ын тушаал
- Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг бүртгэх тухай, ЭМС-ын тушаал